

**МОНГОЛ УЛС, ОЛОН УЛСЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК
ХООРОНДЫН “ЭРЧИМ ХҮЧ-4 ТӨСӨЛ”-ИЙН ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙН
ТӨСЛИЙГ ЗӨВШИЛЦӨХ ТАЛААРХ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 03 дугаар
сарын 31-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдөр Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын “Эрчим хүч-4 төсөл”-ийн Зээлийн хэлэлцээрийн төслийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой зөвшилцөхөөр ирүүлсэн билээ.

Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаараа дээрх хэлэлцээрийн төслийн зөвшилцөх асуудлыг хэлэлцлээ.

“Эрчим хүч-4” төсөл буюу Мандалговь-Арвайхээр чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээт 287км урт цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг өргөтгөх төсөл нь Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан өндөр ач холбогдолтой төсөл бөгөөд Засгийн газраас тус төслийг Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкнаас олгох 78.0 сая ам.долларын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэхдээ Өрийн удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3-д заасны дагуу зээлийн хөрөнгийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-д дамжуулан зээлдүүлэхээр төлөвлөсөн байна.

Тус зээлийн хугацаа 25 жил, үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа 5 жил, баталгаат овернайт санхүүжилтийн хүү (SOFR) дээр 1.4 хувийн нэмэгдэлтэй, хувьсах хүүтэй байх бөгөөд зээлийн хэлэлцээрийг Олон улсын гэрээний тухай хуулийн дагуу Монгол Улсын Их Хурлаар соёрхон батална.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцээрийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд Мандалговь болон Арвайхээрт зөвхөн цахилгаан дамжуулах агаарын шугам барих нь хангалтгүй, дулааны цахилгаан станц барихаар төлөвлөж байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга 78 сая ам.долларын зээл нь зээлийн таазад нөлөөлөх эсэх, төслийн шалгуурын талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг зээлийн хөрөнгөөр дулаан, цахилгааны эх үүсвэр барихаас илүүтэйгээр цахилгаан дамжуулах шугам барихаар төлөвлөсөн нь яагаад илүү оновчтой гэж үзсэн, мөн эрчим хүчний салбарт одоо мөрдөж байгаа тарифаа нэмэгдүүлэхгүйгээр зээлийн эргэн төлөлтийг бүрэн төлөх боломжтой эсэх, тариф нэмэгдүүлэхтэй холбоотой тооцоолол байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай тус төслийг яагаад Мандалговиор дамжуулах болсон, Улаанбаатараас дамжуулах боломжийг судалсан эсэх, төсөл хугацаандаа хэрэгжихгүй байх, зардал өсөх, төсөвт дарамт үүсгэх зэрэг эрсдэлүүдийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа эрчим хүчний салбарт хэрэгжиж байгаа төслүүд гадаадын зээл тусламжийн хэдэн хувийг эзэлж байгаа, эргэн төлөлт төлөвлөгөөний дагуу төлөгдөж байгаа эсэх, Эрчим хүчний яам нь цаашид салбартаа тулгамдаад байгаа асуудалд ямар арга хэмжээ авах талаар, Улсын Их Хурлын

гишүүн Б.Пунсалмаа “Эрчим хүч-4” төсөл буюу Мандалговь-Арвайхээр чиглэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг өргөтгөх төсөл нь Улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан боловч хугацаа алдаж 2026 онд зээлийн хэлэлцээр орж ирж байгаа талаар, төслийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийх боломжтой байсан эсэх, улсын төсвөөс нэмэлт зардал гарах эсэх талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар зээлийн хэлэлцээрийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд төслийн төсөв өртөг өндөр байгааг хэрэгжүүлэх явцад анхаарч бууруулах талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг бага хүүтэй боломжийн нөхцөлтэй тус зээлийг дэмжиж байгаа бөгөөд цаашид зээлийн хөрөнгөөр дулаан, цахилгааны эх үүсвэр барих асуудалд анхаарах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкнаас олгож буй энэхүү зээл нь нэн хөнгөлөлттэй, хамгийн таатай нөхцөлтэй талаар тус тус саналаа хэлсэн болно.

Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын “Эрчим хүч-4 төсөл”-ийн Зээлийн хэлэлцээрийн төслийг зөвшилцөхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 59.1 хувийн саналаар зөвшилцөхийг дэмжиж, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Р.СЭДДОРЖ